



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/668

Булган сум

┌ Сонгуулийн санал авахтай холбогдуулан
зарим үйл ажиллагааг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн хэмжээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн санал авах өдөр, санал авах өдрийн өмнөх болон дараагийн өдөр буюу 2024 оны 10 дугаар сарын 10,11,12-ны өдрүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн санал авах өдөр 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр соёл, урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллуулахыг тус тус хориглосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ